

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР
“СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ХЭРЭГЖИЛТ

2025 оны 12 дугаар сарын 19

Улаанбаатар хот

“Тус газар нь 2025 оны сургалтын төлөвлөгөөнд хүний нөөцийн төвөөс зохион байгуулах сургалт, албан хаагчдыг хамруулах бусад сургалт гэсэн 2 чиглэлээр нийт 11 сургалтыг төлөвлөсөн.

Сургалтын үнэлгээ/ гүйцэтгэл		Нийт
Хяналтад авсан нийт сургалтын тоо		11
1	Хэрэгжсэн	11
2	Хэрэгжээгүй	-
3	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	-
Хэрэгжилтийн дундаж		100%

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын гурав дугаар хавсралтаар баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”-д заасан аргачлалын дагуу хяналт – шинжилгээ хийхэд “Хэрэгжсэн” 11 төрлийн сургалт, “Хэрэгжээгүй” болон “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй” үүрэг даалгавар байхгүй байна.

$$\text{Сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн ерөнхий дүн} = \frac{11}{11-0} \times 100\% = 100\%$$

Нийслэлийн өмчийн харилцааны газрын 2025 оны “Сургалтын төлөвлөгөө”-ний биелэлт 100% хувьтай гүйцэтгэсэн байна.

НЭГТГЭСЭН: ӨХШХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН



Ш.ДАРЬСҮРЭН

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
2025 ОНЫ СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2025 оны 12 дугаар сарын 01

Улаанбаатар хот

Д/д	Сургалтын нэр	Сургалтын зорилго	Хүрэх үр дүн буюу эзэмших үр чадвар	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт
1	2	3	4	5	6
Нэг. Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулах сургалт					
1.1. Ажлын байрны үр чадварын сургалт					
1	Хууль эрх зүй	Төрийн албан хаагч өөрийн хариуцсан ажлын чиг үүрэгтэй холбоотой хууль эрх зүйн мэдлэг хуримтлуулж, үндэснийхээ хуулийн тогтолцоотой танилцаж, ажил хэрэгт зайлшгүй шаардагдах хууль эрх зүйн анхан шатны мэдлэг олгоно. Мөн төрийн албан хаагчид иргэд, хуулийн этгээдээс ирсэн өргөдөл, гомдлыг хууль эрх зүйн талаас нь хэрхэн ойлгуулах, шийдвэрлэх аргачлалд сургана.	Төрийн албан хаагч иргэдийн асуудлыг шийдвэрлэхэд ямар чиг үүрэг хүлээх, иргэд ямар оролцоотой байх, иргэнд үйлчилгээ үзүүлэх, өргөдөл гомдлыг нь шийдвэрлэхдээ ямар зарчим баримтлах, хууль, эрх зүйн актыг хэрхэн сонгох, хэрэглэх, тайлбарлах талаар системтэй ойлголт авч, зохих аргачлалыг эзэмшинэ.	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	ННЗБ-уудын хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан сургалтад 2025.03.25-ны өдөр 3 албан хаагч хамрагдсан. Нийслэлийн Засаг захиргааны нэгжийн шинэчлэл ба Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн танилцуулга сургалтад 2025.04.30-ны өдөр 3 албан хаагч, нийт 6 албан хаагч хамрагдсан. /Хавсралт №7/ /Хавсралт №13/
2	Төрийн архив, албан хэрэг хөтлөлт	Төрийн албан хаагч өдөр тутмын ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах баримт бичгийн найруулга зүй, зөв бичих дүрмийн мэдлэгээ сайжруулж, баримт бичгийн төсөл хэрхэн боловсруулах талаарх	Төрийн албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн бичвэрийн бүтэц, зохион байгуулалт, найруулга зүйн ерөнхий шаардлага, анхаарах асуудлуудыг мэдэж, зөв жишээ болон алдаатай загвар дээр	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	Архив, албан хэрэг хөтлөлтийн шинэчлэгдсэн журмын талаарх сургалтад 2025.04.23-ны өдөр 6 албан хаагч хамрагдсан. /Хавсралт №13/

1	2	3	4	5	6
		чадвартай болно. Мөн баримт бичиг бүрдүүлэх мэдлэг чадвар олгоно.	ажилласнаар баримт бичиг боловсруулах ур чадвар ахина.		
3	Төрийн байгууллагад нийтлэг хөтлөгддөг баримт бичиг боловсруулах арга зүй сургалтад х арга зүй	Төрийн албан хаагчийн өдөр тутмын ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай баримт бичгийн найруулга зүй, зөв бичих дүрмийн мэдлэгийг сайжруулан, баримт бичгийн төсөл боловсруулах чадвар олгож, мөн баримт бичгийн бүрдлийн талаар мэдлэг чадвар эзэмшүүлнэ.	Төрийн албан хэрэг хөтлөлт, монгол бичиг, баримт бичгийн бичвэрийн бүтэц, зохион байгуулалт, найруулга зүйн ерөнхий шаардлага, анхаарах асуудлуудыг мэдэж, зөв болон алдаатай жишээ загвар дээр ажилласнаар баримт бичгийн стандартын дагуу албан бичиг боловсруулах, ур чадвартай болно.	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	Төрийн байгууллагад нийтлэг хөтлөгддөг баримт бичиг боловсруулах арга зүй сургалтад 2025.04.18-ны өдөр 2 албан хаагч хамрагдсан. /Хавсралт №13/ Монгол бичгийн цахим бичвэр сэдэвт сургалтад 2025.05.23-ны өдөр 5 албан хаагч, нийт 7 албан хаагч хамрагдсан. /Хавсралт №17/
1.2. Ажлын байрны цахим хэрэглээний сургалт					
4	Цахим орчны боломжийг ашиглан ажлын бүтээмжээ нэмэгдүүлэх	Энэ сургалт нь цаг их зарцуулдаг техник ажлуудыг хөнгөвчилж бүтээмжээ нэмэх, боловсруулж буй мэдээллийг чанаржуулах, баяжуулах, илүү дэвшилтэт аргуудыг санал болгодог эх үүсвэртэй холбогдож сургах зорилготой.	Цахим орчны өргөн, нээлттэй, үнэ төлбөргүй боломжуудыг ашиглан ажлын бүтээмж, хурд, гүйцэтгэлээ нэмэх, цахим ур чадвараа сайжруулахад суралцана.	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	Цахим орчны боломжийг ашиглан ажлын бүтээмжээ нэмэгдүүлэх нь сэдэвт сургалтад 2025.04.09, 2025.04.16-ны өдрүүдэд 5 албан хаагч хамрагдсан. Хурал уулзалтыг амжилттай, үр дүнтэй явуулахад технологи ашиглах чадавх сэдэвт сургалтад 2025.05.09-ний өдрүүдэд 2 албан хаагч хамрагдсан. /Хавсралт №13/ /Хавсралт №17/
1.3. Зөөлөн ур чадварын сургалтууд					
5	Стресс менежмент	Төрийн албан хаагчид хувийн болон нийгмийн стрессийг зөв аргаар зохицуулж, ажил	- Стрессийн тухай ойлголт - Стрессийг удирдах нь - Стресс үүсгэгч ба үр дагавар	Сургалтад хамрагдсан албан	Стресс менежмент сэдэвт сургалтад 2025.04.25-ны өдрүүдэд 2 албан хаагч хамрагдсан.

1	2	3	4	5	6
		амьдралын тэнцвэрт байдлыг хангаж, ажлын байран дахь стрессийн төрлийг танин мэднэ.	Стрессийг удирдах арга зүй	хаагчийн тоо	/Хавсралт №13/
6	Төрийн албан хаагчийн манлайлал	Төрийн албан хаагчид олж авсан мэдлэг ур чадвараа өөрийн мэдлэгтэй нийцүүлж, байгууллагын үйл ажиллагааг сайжруулж, үр дүнтэйгээр удирдан зохион байгуулж, манлайлах ур чадварт суралцана.	- Манлайллын тухай ерөнхий ойлголт - Манлайллын тухай онол, үзэл баримтлалууд - Хувь хүний ур чадвар, манлайлах чадвараа хөгжүүлэх нь - Хамтын манлайллын тухай	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	Урам зоригтойгоор төрийн албаны үнэ цэнийг бүтээх нь сэдэвт сургалтад 2025.05.08-ны өдрүүдэд 2 албан хаагч хамрагдсан. /Хавсралт №17/
Хоёр. Албан хаагчдыг хамруулах бусад сургалт					
7	Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалт	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгоход оршино.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэгтэй болно.	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад байгууллагын хэмжээнд нийт 2 албан хаагч (Б.Баясалмаа, Э.Будханд) хамрагдаж төгссөн. /Хавсралт №31/
8	Компанийн засаглалын сургалт	Компанийн засаглалын хяналтын тогтолцоог бүрдүүлэх, удирдах мэдлэг чадвар эзэмшүүлэх зорилготой.	Компанийн тухай хуулийн 75.8 дахь заалтын дагуу Компанийн засаглалын талаар мэдлэг чадвартай болсон байна.	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нарт зориулсан компанийн засаглалын богино хугацаат сургалтад 6 албан хаагч хувийн зардлаар хамрагдсан ба байгууллагын хэмжээнд нийт 14 албан хаагч (В.Оюумаа, Б.Баясалмаа, Т.Оюунтуул, Г.Тэмүүжин, С.Эрдэмсүвд, Г.Даваамөнх, Ж.Сувданзаяа, Б.Адъяа, Ш.Дарьсүрэн, С.Сэржжаргал, Б.Батаа, М.Энхболд, Ц.Даваажав, Ч.Хоролгарав) тус сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна. /Хавсралт №20/

1	2	3	4	5	6
9	Удирдлагын академийн мэргэшүүлэх багц сургалт	Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалт, төрийн жинхэнэ албан хаагчийг мэргэшүүлэх мэргэшүүлэх давтан сургалт, ахлах түшмэл, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад албан хаагчдыг хамруулах	Мэдлэг чадвараа дээшлүүлж, холбогдох сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	Байгууллагын хэмжээнд Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1 албан хаагч (В.Оюумаа), Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 2 албан хаагч (В.Оюумаа, Б.Баясалмаа), Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3 албан хаагч (Б.Баясалмаа, Б.Мягмардорж, С.Сэржжаргал) хамрагдаж төгссөн, 2 албан хаагч (Т.Оюунтуул, Мя.Энхбаяр) хамрагдаж байна. Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх болон мэргэшүүлэх давтан сургалтад 4 албан хаагч (Ш.Дарьсүрэн, Мя.Энхбаяр, С.Гончигсумлай, П.Түвшинжаргал) хамрагдаж төгссөн, 3 албан хаагч (Г.Даваамөнх, М.Энхбаяр, Б.Анужин) хамрагдаж байна. Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 2 албан хаагч (Г.Даваамөнх, С.Эрдэмсүвд) хамрагдаж төгссөн байна.
10	Шинэ албан хаагч дадлагажуулах сургалт	Шинээр томилогдсон албан хаагчид зайлшгүй мэдэх мэдлэгийг олгоход оршино.	Мэдлэг чадвараа дээшлүүлж, холбогдох сургалтад хамрагдсан байна.	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	“Хөдөлмөрийн харилцаатай холбоотой хуулийн зохицуулалт, байгууллагын болон албан тушаалын чиг үүрэг, бусад шаардагдах цахим хаяг, системийн талаарх мэдлэг олгох” 8 удаагийн сургалтад тус газарт шинээр томилогдсон 10 албан хаагчдад хаагчийг хамруулсан. /Хавсралт №30/
11	Цаг үеийн шинжтэй зохион байгуулсан бусад сургалт	Тухайн чиглэлээр мэдлэг чадвар олгоход чиглэнэ.	Мэдлэг чадвараа дээшлүүлж, холбогдох сургалтад хамрагдсан байна.	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	Байгууллагын батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу бусад байгууллагаас зохион байгуулсан 25 удаагийн сургалтад давхардсан тоогоор 105 албан хаагчдыг хамруулсан. Үүнд: /Хавсралт №32/

1	2	3	4	5	6
					1. Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс зохион байгуулсан "Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтнуудын 3 цагийн сургалт"-д 2025.01.31-ний өдөр 1 албан хаагч; /Хавсралт №1/ 2. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "Төрийн албаны хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны цахим системийн төрийн албан хаагчийн оролцоо модуль, дэд системүүдийг танилцуулах 2 цагийн сургалт"-д 2025.01.31-ний өдөр 1 албан хаагч; /Хавсралт №2/ 3. Монгол Улсын Ёс зүйн хорооноос зохион байгуулсан "Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдийг чадавхжуулах 2 цагийн сургалт"-д ёс зүйн дэд хорооны 5 гишүүн; /Хавсралт №3/ 4. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохион байгуулсан "Төрийн болон орон нутгийн өмчийн газрын бүртгэл, ашиглалт хариуцсан албан хаагчдад зориулсан сургалтад 2025.02.10-11-ний өдрүүдэд 8 албан хаагч; 5. Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Албан хэргийг хос бичгээр хөтлөх архивын нэгж бүрдүүлэх 2 цагийн сургалт"-д 2025.02.12-ны өдөр 7 албан хаагч; /Хавсралт №5/ 6. НЗДТГ-аас зохион байгуулсан "ННЗБ-уудын хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан сургалт"-д 2025.03.25-ны өдөр 3 албан хаагч; /Хавсралт №6/ 7. Удирдлагын академиас зохион байгуулсан "Байгууллагын эерэг соёлыг бүрдүүлэх нь сэдэвт 16 цагийн сургалт"-д 2025.03.13-14-ний өдрүүдэд 4 албан хаагч;

1	2	3	4	5	6
					8. НЗДТГ-ын Мэдээлэл технологийн газраас зохион байгуулсан “Нээлттэй мэдээллийн shien.gov.mn системд байршуулсан шилэн индексийн тайлан илгээх, үнэлэх, хянан баталгаажуулах сургалт”-д 2025.03.25-ны өдөр 1 албан хаагч; /Хавсралт №8/ 9. Нийслэлийн Онцгой байдлын газраас зохион байгуулсан “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ сэдэвт сургалт”-д 2025.03.26-ны өдөр 28 албан хаагч; /Хавсралт №10/ 10. НЗДТГ-аас зохион байгуулсан “Фидик гэрээний сургалт”-д 2025.03.31, 2025.04.01-ний өдрүүдэд 3 албан хаагч; /Хавсралт №11/ 11. Засгийн газрын хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан “Монгол Улсын төрийн албаны гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх нь 2023-2025 төслийн зөвлөх үйлчилгээний тайлан хүлээн авах, танилцуулах 4 цагийн сургалт”-д 2025.04.04-ний өдөр 1 албан хаагч; /Хавсралт №12/ 12. НЗДТГ-аас зохион байгуулсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах арга зүй сэдэвт 4 цагийн сургалт”-д 2025.04.18-ны өдөр 4 албан хаагч; /Хавсралт №14/ 13. НЗДТГ-аас зохион байгуулсан “Ахмадын туршлага байгууллагын хөгжил” цагийн хэлэлцүүлэг”-т 2025.5.25-ны өдөр 2 албан хаагч; /Хавсралт №15/ 14. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохион байгуулсан “Төрийн болон орон нутгийн өмчийн 2025 оны тайлан, мэдээ

1	2	3	4	5	6
					нэгтгэл сэдэвт сургалт"-д 2025.05.05-09-ний өдрүүдэд 10 албан хаагч; 15. ННЗБ-уудын төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг зөвлөн чиглүүлэх менторшип хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан сургалтад 2025.05.07-ны өдрүүдэд 3 албан хаагч; 16. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "Бүсчилсэн хөгжил- Төрийн албаны манлайлал" нийслэлийн бүсийн төрийн албан хаагчдын зөвлөгөөн хэлэлцүүлэгт 2025.05.28-29-ний өдрүүдэд 3 албан хаагч; 17. НЗДТГ-аас зохион байгуулсан "Төрийн албанд анх томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх хөтөлбөрийн хаалтын арга хэмжээ, сургалт"-д 2025.06.10-ны өдөр 3 албан хаагч; 18. НЗДТГ-аас зохион байгуулсан MNS ISO 9001:2015 дотоод аудитор бэлтгэх сургалтад 2025.06.04-13-ны өдрийн хооронд 1 албан хаагч; 19. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас зохион байгуулсан "Улсын төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалтын удирдлагын нэгдсэн цахим системийн сургагч багш бэлтгэх сургалт"-д 2025.08.25-27-ны өдрийн хооронд 4 албан хаагч; 20. Нийслэлийн Архивын газраас зохион байгуулсан "Төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтөлтийн ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх сургалт"-д 2025.09.16-ны өдөр 3 албан хаагч;

1	2	3	4	5	6
					21. НЗДТГ-аас зохион байгуулсан Хүний нөөцийн ажилтны өдрийг утган "HR 2025 сургалт, уулзалтад 2025.10.15-ны өдөр 1 албан хаагч; /Хавсралт №25/ 22. НЗДТГ-аас зохион байгуулсан Хяналт шинжилгээ, үнэлгээ хийх журам, Үнэлгээ хийх журам, Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэх журам танилцуулах сургалтад 2025.10.17-ны өдөр 3 албан хаагч; /Хавсралт №26/ 23. Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан "Төрийн байгууллагын хүний нөөцийн мэдээллийг Power BI дашбордад шилжүүлж, удирдлагын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх сургалт"-д 2025.10.01-23-ны өдрүүдэд 2 албан хаагч; 24. НИТХ-аас зохион байгуулсан "Нийслэлийн нутгийн захиргааны болон нийслэлийн өмчид байгууллагуудын хуулийн асуудал хариуцсан албан хаагчдыг чадавхжуулах чиглэлээр зохион байгуулагдаж буй хэлэлцүүлэг"-т 2025.11.09-ний өдөр 3 албан хаагч; /Хавсралт №27/ 25. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж буй Төрийн байгууллагуудаас авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах сургагч багш бэлтгэх сургалтад 1 албан хаагч; /Хавсралт №28/ 26. Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 2025.06.19-2025.06.21-ний өдрийн хооронд зохион байгуулагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн хэрэгжилтийг хангах, өмчийн удирдлага, зохицуулалтын системийг нэвтрүүлэх, хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлж буй арга туршлага солилцох онол

1	2	3	4	5	6
					арга зүйн мэдлэг олгох сургалт"-д хамрагдсан 7 албан хаагч; 27. АТГ-ын шинэчлэгдсэн Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн систем https://meduulleg.iaas.mn/-ийн сургалтад 1 албан хаагч; 28. Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан "Нийслэлийн төсөв асуудал, шийдэл: Иргэдийн хяналт" сэдэвт сургалт хэлэлцүүлэгт 2025.12.09-ний өдөр 1 албан хаагч; 29. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас зохион байгуулсан "Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэх журмын зохицуулах харилцаа, дүн шинжилгээ хийх, хүргүүлэхтэй холбоотой зохицуулалтыг танилцуулах сургалтад 2025.12.11-ний өдөр 2 албыан хаагчийг тус тус хамруулсан. /Хавсралт №33/ /Хавсралт №36/ НЗДТГ-аас 2025.03.28-ны 02-02/1865 дугаартай албан бичгээр ирүүлсэн Нийслэл хотод хэрэгжүүлэх 24 мега төслийн танилцуулгын хүрээнд албан хаагчид болон олон нийтэд үнэн, зөв мэдээллийг үе шаттайгаар танилцуулах төлөвлөгөөг гаргаж, 2025.03.31-ний өдрийн сургалтаар "Түгжрэлийг бууруулах ажил"-ын хүрээнд хийгдэх 10 мега төсөл, 2025.04.07-ны өдрийн сургалтаар "Агаарын бохирдлыг бууруулах" ажлын хүрээнд хийгдэх 6 мега төсөл, 2025.04.11-ний өдрийн сургалтаар "Иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэх" ажлын хүрээнд хийгдэх 8 мега төслийн танилцуулгыг хийж, тайланг 2025.04.14-ний өдрийн 1/568 дугаарт албан бичгээр Нийслэлийн Засаг Даргын тамгын газарт хүргүүлсэн болно.

1	2	3	4	5	6
					/Хавсралт №34/ Мөн Монгол Улсын Засгийн Газар, Япон улсын Засгийн газартай хамтран хэрэгжүүлдэг "Хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөр"-ийн мэдээллийг 2025.09.16-ны өдөр нийт албан хаагчдад танилцуулж ажилласан. /Хавсралт №35/

ТАНИЛЦСАН
НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГА

Б. Даваа

/В.ОЮУМАА/

ХЯНАСАН

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТЭСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Г. Даваа

Л.ОЮУНТУУЛ/

ӨМЧИЙН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ХЭЛТЭСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Ц.О

1 *Ц. Даваа* 20/19

БОЛОВСРУУЛСАН

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН ХЭЛТЭСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Г. Даваа

/Г.ДАВААМӨНХ/